



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 09 сарын 26 өдөр

Дугаар А/498

Мөрөн сум

Барилга байгууламжийн ажлыг
хүлээж авах комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.2, 35.1.6, 48 дугаар зүйлийн 48.6, Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хөвсгөл аймгийн Арбулаг сумын 250 хүний суудалтай соёлын төвийн барилгын ажлыг хүлээн авч ашиглалтад оруулах чиг үүрэг бүхий комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга: Н.Шинэбаяр (Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга)

Гишүүд:

- Д.Сандагдорж (Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө
оруулалтын хэлтсийн мэргэжилтэн, Ерөнхий архитектор)
- Б.Гал-Эрдэнэ (Аймгийн Мэдээлэл холбоо сүлжээний хяналтын
улсын байцаагч)
- Г.Золбоо (Барилгын хөгжлийн төвийн ББЗХ Хэлтсийн хяналтын
инженер)
- Д.Мягмарсүрэн (Хөвсгөл аймгийн Газрын харилцаа барилга,
хот байгуулалтын газрын Барилга техникийн
хяналтын улсын байцаагч)
- Д.Аюушжав (Аймгийн Эрчим хүчний хяналтын улсын байцаагч)
- Г.Ням-Эрдэнэ (Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Хууль, эрх зүйн хэлтсийн Архивын
тасгийн Сан хөмрөгийн эрхлэгч)
- Л.Бямбасүрэн (Аймгийн Онцгой байдлын газрын Гамшгаас
хамгаалах улсын хяналтын байцааг, дэд хурандаа)
- Д.Аюуш (Хөвсгөл Эрчим Хүч ХХК-ийн Ашиглалтын албаны дарга)
- Ш.Нямханд (Хөвсгөл дулааны станц ТӨХК-ийн
ерөнхий инженер)
- Д.Сүхээ (Хөвсгөл Ус суваг ХХК-ийн ерөнхий инженер)
- Ж.Лувсанням (Мэдээлэл холбоо сүлжээ ТӨХК-ийн ерөнхий инженер)
- Г.Дэлгэрнасан (Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийн
мэргэжилтэн)

Ашиглагч байгууллагыг төлөөлөл:

Б.Гантулга	(Арбулаг сумын Засаг дарга)
М.Хэнчбиш	(Арбулаг сумын соёлын төвийн эрхлэгч)
Э.Лхагвасүрэн	(Арбулаг сумын соёлын төвийн нягтлан)

Зураг төслийн байгууллагын төлөөлөл:

Д.Лхагважав	(“Рулер констракшн” ХХК-ийн захирал)
-------------	--------------------------------------

Гүйцэтгэгч байгууллагын төлөөлөл:

Д. Батдаваа	(“Цэгц мандал” ХХК-ийн захирал)
Ц.Мөнхбат	(“Цэгц мандал” ХХК-ийн инженер)

Комиссын нарийн бичгийн дарга:

Б.Энхжаргал	(Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын мэргэжилтэн)
-------------	--


2.Арбулаг сумын 250 хүний суудалтай соёлын төвийн барилгын ажлыг хүлээж авах үйл ажиллагааг холбогдох хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулж, комиссын ажлын тайлан, шийдвэрийг олон нийтэд мэдээлж ажиллахыг Комиссын дарга (Н.Шинэбаяр)-д даалгасугай.

3.Арбулаг сумын 250 хүний суудалтай соёлын төвийн барилгын ажлыг хүлээж авсантай холбоотой баримт бичгийг бүрдүүлэн аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн Архивын тасаг болон холбогдох байгууллагуудад хүлээлгэн өгөхийг Комиссын нарийн бичгийн дарга (Б.Энхжаргал) -д үүрэг болгосугай.

4.Комиссын бүрэлдэхүүн чанаргүй барилга байгууламж хүлээн авсан тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгүүлэхийг анхааруулсугай.

5.Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Э.Улам-Өсөх)-т үүрэг болгосугай.

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ